



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/099/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2025 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авсна уу. .

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Н.ЕРЖАН ТАНАА

2025.02.25 № 94
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нь 2025 онд 22,767.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 23,165.2 сая төгрөг зарцуулж, 101.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

83290500106

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,637,619,633.71</u>	<u>4,081,548,850.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	82,800.00	23,024,422.07
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	82,800.00	23,024,422.07
3121	Төгрөг	82,800.00	23,024,422.07
31211	Төрийн сангийн харилцах	82,800.00	23,024,422.07
33	АВЛАГА	442,524,922.65	2,989,362,877.92
335	Бусад авлага	442,524,922.65	2,989,362,877.92
3351	Байгууллагаас авах авлага	442,524,922.65	2,989,362,877.92
35	БАРАА МАТЕРИАЛ	1,195,011,911.06	1,069,161,550.68
351	Түүхий эд материал	724,434,262.86	572,020,327.54
35130	Эм боох материал	724,434,262.86	572,020,327.54
35300	Бэлэн бүтээгдэхүүн	20,000.00	20,000.00
354	Хангамжийн материал	470,557,648.20	497,121,223.14
35410	Бичиг хэргийн материал	25,608,364.90	18,925,464.90
35420	Аж ахуйн материал	190,656,100.37	207,948,113.50
35430	Сэлбэг хэрэгсэл	1,866,591.69	1,380,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,209.95	779,209.95
35450	Барилгын засварын материал	46,604,049.37	49,199,189.37
35460	Хүнсний материал	55,086.50	
35470	Бусад хангамжийн материал	205,763,245.42	218,889,245.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,391,387,591.23</u>	<u>29,778,262,729.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,391,387,591.23	29,778,262,729.93
392	Биет хөрөнгө	30,848,934,042.45	29,241,276,305.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,646,203,628.09	15,073,332,370.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,069,363,759.51)	(2,510,841,016.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,598,126,978.30	1,598,126,978.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	(475,593,390.10)	(696,182,071.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,345,225,683.97	13,786,064,505.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,235,023,826.07)	(8,909,175,105.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	651,893,738.84	655,812,848.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(270,926,718.10)	(402,279,698.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	170,453,545.36	170,453,545.36
39215	Хуримтлагдсан элэгдэл	(65,897,350.79)	(77,871,562.07)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	10,552,899,449.00	10,552,899,449.00
39217	Ном	936,063.46	936,063.46
393	Биет бус хөрөнгө	542,453,548.78	536,986,424.34
39301	Програм хангамж	58,832,122.00	58,832,122.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28,095,773.22)	(36,925,197.66)
39303	Бусад биет бус хөрөнгө	515,079,500.00	515,079,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,362,300.00)	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>33,029,007,224.94</u>	<u>33,859,811,580.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,173,675,732.65</u>	<u>3,560,944,697.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,173,675,732.65	3,560,944,697.43
413	Өглөг	2,173,675,732.65	3,560,944,697.43
4136	Бусад өглөг	2,173,675,732.65	3,560,944,697.43

41361	Байгууллагад төлөх өглөг	2,163,695,532.65	3,560,944,697.43
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,980,200.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	30,855,331,492.29	30,298,866,883.17
51	Засгийн газрын хувь оролцоо	30,855,331,492.29	30,298,866,883.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,633,020,649.16	4,633,020,649.16
51101	Өмч: - төрийн	4,633,020,649.16	4,633,020,649.16
512	Хуримтлагдсан үр дүн	17,900,953,968.59	17,345,021,465.10
51210	Өмнөх үеийн үр дүн	18,782,817,786.99	17,890,040,374.22
51220	Тайлант үеийн үр дүн	(881,863,818.40)	(545,018,909.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,321,356,874.54	8,320,824,768.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	33,029,007,224.94	33,859,811,580.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22,997,287,518.66	26,376,526,303.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,062,043,592.66	1,819,857,709.98
120	Нийтлэг татварын бус орлого	2,062,043,592.66	1,819,857,709.98
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	481,171,210.00	1,166,908,699.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	481,171,210.00	512,495,320.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		654,413,378.12
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,528,859,044.96	634,190,371.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	52,013,337.70	18,758,638.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,935,243,926.00	24,556,668,594.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,124,724,000.00	2,292,227,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,124,724,000.00	2,292,227,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,810,519,926.00	22,264,440,894.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,810,519,926.00	22,264,440,894.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,879,151,337.06	26,921,545,213.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,879,151,337.06	26,901,551,544.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,877,751,335.06	26,219,812,166.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,235,620,293.08	16,538,459,660.30
210101	Үндсэн цалин	13,235,620,293.08	16,535,808,013.30
210102	Нэмэгдэл	-	2,651,647.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,709,113,299.21	-
210201	Тэтгэврийн даатгал	1,709,113,299.21	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,559,435,962.42	1,634,153,732.21
210301	Гэрэл, цахилгаан	186,920,954.42	238,679,856.00
210302	Түлш, халаалт	1,072,515,008.00	1,096,483,876.21
210303	Цэвэр, бохир ус	300,000,000.00	298,990,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	700,589,421.97	656,656,294.88
210401	Бичиг хэрэг	132,173,540.00	130,362,200.00
210402	Тээвэр, шатахуун	256,590,250.00	265,545,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,629,569.97	22,919,208.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	98,610,400.00	110,506,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,216,212.00	127,323,636.88
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	192,369,450.00	-
2105	Нормативт зардал	4,717,540,652.04	4,678,268,832.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,195,482,602.04	4,143,422,786.10
210502	Хоол, хүнс	501,564,050.00	526,125,046.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,494,000.00	8,721,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,150,472.00	127,288,803.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,443,000.00	370,000.00
210604	Урсгал засвар	58,707,472.00	126,918,803.69
2107	Томилолт, зочны зардал	74,778,384.00	69,486,900.00
210702	Дотоод албан томилолт	74,778,384.00	69,486,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,191,294.97	211,714,328.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,000,000.00	190,509,380.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	630,000.00	1,520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,725,974.00	9,108,364.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	455,350.00	1,431,855.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	407,000.00	407,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210807	Газрын төлбөр	5,972,970.97	8,553,029.03
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	184,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,798,331,555.37	2,303,783,614.89
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,798,331,555.37	2,303,783,614.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,002.00	681,739,378.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	654,939,378.12
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	352,475,378.12
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	301,536,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	928,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	26,800,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		26,800,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,993,668.38
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,993,668.38
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/		19,993,668.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(881,863,818.40)	(545,018,909.12)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(881,863,818.40)	(545,018,909.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	21,574,572,441.42	23,214,917,410.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	481,097,210.00	1,166,908,699.05
120	Нийтлэг татварын бус орлого	481,097,210.00	1,166,908,699.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	481,097,210.00	1,166,908,699.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	481,097,210.00	512,495,320.93

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		654,413,378.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,093,475,231.42	22,048,008,711.66
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,124,724,000.00	2,292,227,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,124,724,000.00	2,292,227,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,968,751,231.42	19,755,781,011.66
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,968,751,231.42	19,755,781,011.66
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	21,521,579,251.42	23,104,068,038.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,521,579,251.42	23,104,068,038.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,520,179,249.42	22,422,328,660.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,477,799,774.00	13,740,061,883.59
210101	Үндсэн цалин	7,212,293,640.00	7,732,903,912.29
210102	Нэмэгдэл	5,133,688,826.00	5,101,578,294.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	511,510,332.00	596,941,400.23
210104	Урамшуулал	620,306,976.00	308,638,277.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,890,788,400.00	1,724,031,000.00
210201	Тэтгэврийн даатгал	1,332,850,100.00	1,172,341,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	139,484,600.00	137,922,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	69,742,300.00	68,961,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	69,742,300.00	68,961,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	278,969,100.00	275,845,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,338,624,398.00	2,130,719,428.00
210301	Гэрэл, цахилгаан	186,920,954.42	238,679,856.00
210302	Түлш, халаалт	886,265,780.00	1,559,047,235.58
210303	Цэвэр, бохир ус	265,437,663.58	332,992,336.42
2104	Хангамж, бараа материалын зардал	599,143,950.00	519,075,801.11
210401	Бичиг хэрэг	50,961,240.03	67,348,559.97
210402	Тээвэр, шатахуун	257,070,850.00	263,269,974.41
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,629,569.97	23,740,685.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	226,113,000.00	131,268,581.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,369,290.00	33,448,000.00
2105	Нормативт зардал	3,915,237,896.45	3,936,151,132.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,397,007,246.45	3,394,023,332.70
210502	Хоол, хүнс	501,564,050.00	520,590,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,666,600.00	21,537,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	168,621,152.00	189,360,272.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,092,600.00	31,216,420.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,473,200.00	
210604	Урсгал засвар	124,055,352.00	158,143,852.00
2107	Томилолт, зочны зардал	74,778,384.00	69,486,900.00
210702	Дотоод албан томилолт	74,778,384.00	69,486,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,185,294.97	113,442,243.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,000,000.00	65,775,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	630,000.00	1,520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,725,974.00	9,108,364.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	455,350.00	464,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	407,000.00	407,000.00
210807	Газрын төлбөр	5,972,970.97	8,166,399.12
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,994,000.00	28,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,002.00	681,739,378.12

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	654,939,378.12
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	352,475,378.12
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	301,536,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	928,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2.00	26,800,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2.00	26,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,993,190.00	110,849,372.07
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,374,390.00	87,907,750.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,374,390.00	87,907,750.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,374,390.00	87,907,750.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,374,390.00	87,907,750.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(54,374,390.00)	(87,907,750.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,381,200.00)	22,941,622.07
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,464,000.00	82,800.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	82,800.00	23,024,422.07

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,633,020,649.16	8,321,850,197.74	18,781,903,607.74	31,737,195,310.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			420,856.05	420,856.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,633,020,649.16	8,321,850,197.74	18,782,324,463.79	31,737,195,310.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			493,323.20	493,323.20
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-493,323.20		-493,323.20
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-881,863,818.40	-881,863,818.40
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,633,020,649.16	8,321,356,874.54	17,900,953,968.59	30,855,331,492.29
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,633,020,649.16	8,321,356,874.54	17,900,953,968.59	30,855,331,492.29

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-10,913,594.37	-10,913,594.37
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,633,020,649.16	8,321,356,874.54	17,890,040,374.22	30,844,417,897.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		-532,105.63		-532,105.63
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-545,018,909.12	-545,018,909.12
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,633,020,649.16	8,320,824,768.91	17,345,021,465.10	30,298,866,883.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		82,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,767,272,500.00	23,165,175,788.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,767,272,500.00	23,165,175,788.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,095,091,200.00	22,510,236,410.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,792,248,100.00	13,740,061,883.59
210101	Үндсэн цалин	7,645,031,000.00	7,732,903,912.29
210102	Нэмэгдэл	5,190,275,500.00	5,101,578,294.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	626,941,600.00	596,941,400.23
210104	Урамшуулал	330,000,000.00	308,638,277.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,724,031,000.00	1,724,031,000.00
210201	Тэтгэврийн даатгал	1,172,341,100.00	1,172,341,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	137,922,500.00	137,922,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	68,961,200.00	68,961,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,961,200.00	68,961,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	275,845,000.00	275,845,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,225,882,700.00	2,130,719,428.00
210301	Гэрэл, цахилгаан	181,655,500.00	238,679,856.00
210302	Түлш, халаалт	1,720,227,200.00	1,559,047,235.58
210303	Цэвэр, бохир ус	324,000,000.00	332,992,336.42
2104	Хангамж, бараа материалын зардал	514,523,000.00	553,336,251.11
210401	Бичиг хэрэг	57,972,600.00	74,908,559.97
210402	Тээвэр, шатахуун	259,440,700.00	263,269,974.41
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,039,900.00	23,740,685.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	129,840,800.00	131,268,581.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,229,000.00	60,148,450.00
2105	Нормативт зардал	3,437,173,600.00	3,936,151,132.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,895,045,800.00	3,394,023,332.70
210502	Хоол, хүнс	524,127,800.00	520,590,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,000,000.00	21,537,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	218,137,000.00	243,007,572.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,000,000.00	47,813,720.00

210604	Урсгал засвар	191,137,000.00	195,193,852.00
2107	Томилолт, зочны зардал	69,490,700.00	69,486,900.00
210702	Дотоод албан томилолт	69,490,700.00	69,486,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,605,100.00	113,442,243.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,925,000.00	65,775,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,520,000.00	1,520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,108,400.00	9,108,364.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,300.00	464,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	407,000.00	407,000.00
210807	Газрын төлбөр	8,166,400.00	8,166,399.12
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	28,000,000.00	28,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	672,181,300.00	654,939,378.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	672,181,300.00	654,939,378.12
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	379,903,300.00	352,475,378.12
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	291,714,000.00	301,536,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	564,000.00	928,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,767,272,500.00	23,188,117,410.71
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,375,882,700.00	2,265,427,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	2,375,882,700.00	2,265,427,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,201,442,700.00	19,755,781,011.66
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,201,442,700.00	19,755,781,011.66
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,189,947,100.00	1,166,908,699.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	518,247,000.00	512,495,320.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	671,617,300.00	654,413,378.12
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	82,800.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		82,800.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		23,024,422.07
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	506	506
620001	Удирдах ажилтан	2	2
620002	Гүйцэтгэх ажилтан	382	382
620003	Үйлчлэх ажилтан	122	122
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	526.0	526.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	377	377
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	129	129

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 23,879.2 сая төгрөгөөс 0.5 хувиар тооцож 119.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 26,921.5 сая төгрөгөөс 0.5 хувиар тооцоход 134.6 сая төгрөг болж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон ба тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс худалдан авах ажиллагааны тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 2,989.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэр, 3,560.9 сая төгрөгийн өр үүсгэсэн 68 шийдвэрийг болон төсөв, өмч хөрөнгө зарцуулах 17 шийдвэрийг байршуулаагүй. Мэдээлсэн байдлын хэрэгжилт 83 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.1.3-т " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор

мэдээлнэ", 6.4.6-д " худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, **төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр**" гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны байршуулаагүй худалдан авах ажиллагааны тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 2,989.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн 2 шийдвэр, 3,560.9 сая төгрөгийн өр үүсгэсэн 68 шийдвэр, төсөв, өмч хөрөнгө зарцуулах 17 шийдвэрийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн зардлаас зориулалт бус зарцуулсан эсэхийг, өр төлбөрийг барагдуулсан байдал болон цалин тогтоолт, олголтыг дэлгэрэнгүй үзнэ.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд нийт 83.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг залруулсан.
Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөөг 83.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой 70.7 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гэрээний дагуу олгох ёстой төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн 70.7 сая төгрөгийг эмийн зардлаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Эмийн зардлаас зориулалт бус зардал гаргахгүй байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан	1	83,655.0			1	83,655.0	1	83,655.0				
Дүн	1	83,655.0			1	83,655.0	1	83,655.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөртэй тусламж үйлчилгээний	1	70,650.0					1	70,650.0				

төлбөрт олгох 70.7 сая төгрөгийг эмийн зардлаас олгосон.												
Дүн	1	70,650.0						1	70,650.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 83 хувьтай байна.	1	6,550,307.6					1	6,550,307.6
Дүн	1	6,550,307.6						6,550,307.6